



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2019 оны 06 сарын 19 өдөр

Дугаар 0/201

Улаанбаатар хот

**“Багануур Тохижилт” ОНӨААТҮГ-ын
данс бүртгэлээс тээврийн
хэрэгсэл хасах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, Нийслэлийн Засаг даргын 2019 оны А/172 дугаар захирамжийг үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн Өмчийн харилцааны газраас 2019 оны 03 дугаар сарын 20-ны өдөр зохион байгуулсан нээлттэй дуудлагын худалдаагаар худалдсан 33,350,000.0 /гучин гурван сая гурван зуун тавин мянган/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий Ниссан сафари маркийн 01-32 БРА улсын дугаартай тээврийн хэрэгслийг данс бүртгэлээсээ хасахыг “Багануур Тохижилт” ОНӨААТҮГ /Д.Батнасан/-т зөвшөөрсүгэй.


2. Өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийхийг “Багануур Тохижилт” ОНӨААТҮГ /Д.Батнасан/-т тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн мэдээлэл, хяналт, ашиглалтын хэлтэс /Н.Раднаасэд/-т тус тус даалгасугай.

ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ



Ш.ҮНЭНБАТ

Нийслэлийн Өмчийн харилцааны газрын
даргын 2019 оны 06 сарын 28 ны өдрийн
..... дугаар тушаалын хавсралт



НЭЭЛТТЭЙ ДУУДЛАГЫН ХУДАЛДААГААР ХУДАЛДСАН,
ДАНСНААС ХАСАХ ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛҮҮД

/төгрөгөөр/

№	Байгууллагын нэр	Марк, дугаар	Үйлдвэрлэг -дсэн он	Баланс үнэ	Байгуулсан элэгдэл	үлдэгдэл үнэ
1	Зорчигч тээврийн нэгтгэл ОНӨААТҮГ	Зил-130 65-94 УББ	1990	3,539,700	3,539,700	-
2		Хьюндай Старекс 81-51 УНМ	1999	9,000,000	9,000,000	-
Нийт дүн				12.539.700	12.539.700	0